

**ХУУЛЬ ЗҮЙН ДОТООД ХЭРГИЙН САЙД,
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2012 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/21/22

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 19.8 дахь заалтыг тустус үндэслэн ТУШААХ нь:

1. “Даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газар /С.Ганболд/, Албан журмын даатгагчдын холбоо /Б.Мөнхбаатар/, Цагдаагийн ерөнхий газар /Д.Сандаг-Очир/-т тус тусдаалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙН ДОТООД ХЭРГИЙН
САЙД

Ц.НЯМДОРЖ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАГЧ, ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААС ХОХИРОГЧИД ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ИРҮҮЛЭХ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгагч болон жолоочийн даатгалын сан (цаашид “сан” гэх)-аас хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Даатгагч нөхөн төлбөртэй холбоотой мэдээлэл ирүүлэх

2.1. Даатгагч жолоочид олгосон нөхөн төлбөрийн талаарх мэдээллийг нэн даруй бүртгэж, Цагдаагийн ерөнхий газар, Албан журмын даатгагчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-нд цахим хэлбэрээр тус тус ирүүлнэ.

2.2. Хохирогчид олгосон нөхөн төлбөрийн талаарх мэдээллийн бүртгэлийг даатгагч энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу цахим мэдээлэлд шивж оруулна.

Гурав. Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөрийн мэдээлэл ирүүлэх

3.1. Даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа нь дууссан, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тогтоогдоогүй, даатгагч дампуурсан зэрэг Жолоочийн даатгалын тухай хуулийн 18.1-т заасан хууль тогтоомжид заасан үндэслэлийн аль нэг нь үүссэн тохиолдолд хохирогчид жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох бөгөөд сан нь энэ тухай мэдээллийн бүртгэл хөтөлнө.

3.2. Хохирогчид энэ журмын 3.1-т заасны дагуу олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг сан нь нэн даруй Цагдаагийн ерөнхий газарт цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.3. Сан нь хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээлэл болон даатгагчаас энэ журмын 2.1-т заасны дагуу ирүүлсэн мэдээллийг нэгтгэж, нэн даруй Санхүүгийн зохицуулах хороонд тайлангаа цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4. Санхүүгийн зохицуулах хороо нь шаардлагатай тохиолдолд даатгагч болон сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх, эсхүл энэхүү зөвшөөрлийг Холбоонд олгож болно.

3.5. Холбоо нь Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн хүрээ, хязгаарын дотор зам тээврийн осол, зөрчлийн улмаас хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг статистик тоон үзүүлэлт байдлаар олон нийтэд мэдээлнэ.

3.6. Энэ журмын 3.2, 3.3-т заасан мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу холбогдох байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Дөрөв. Цагдаагийн байгууллага нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг ашиглах

4.1. Цагдаагийн ерөнхий газар, түүний харъяа алба нь цахим сангаас холбогдох мэдээлэл, статистикийн мэдээг үнэ төлбөргүй авч, үйл ажиллагаандаа ашиглана.

4.2. Цагдаагийн ерөнхий газар, түүний харъяа алба нь цахим сангийн статистик мэдээллийг зам, тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтэд мэдээлж болно.

Тав. Хяналт тавих

5.1. Хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг Цагдаагийн байгууллагад гаргаж өгөхөөс татгалзсан, эсхүл хугацаанд нь хүргүүлээгүй даатгагч болон санд Жолоочийн даатгалын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг удаа дараа хугацаа хоцроох, буруу, дутуу мэдээлэл гаргаж ирүүлэх буюу ирүүлэхээс санаатайгаар зайлсхийвэл Цагдаагийн ерөнхий газар энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, холбогдох даатгагч болон санг шалгуулна.

-----oO-----

“Даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх журам”-ын 1 дүгээр хавсралт

“.....” ХХК-ийн нөхөн төлбөр олгосон талаарх мэдээлэл

№	Даатгалын тохиолдлын утга	ЗХД-ийн ямар заалт зөрчсөн	Даатгалын тохиолдол бий болгосон этгээдийн нэр	Жолооны үнэмлэхний дугаар	Регистр	ТХ-ийн улсын бүртгэлийн дугаар	Даатгалын тохиолдол болсон газар	байг. учир Ам. эрүү
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
	Нийт							

Мэдээ гаргасан:
Даатгалын ажилтан

/...../

Тамга

Хянасан:
Захирал.

/...../

“Даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх журам”-ын 2 дугаар хавсралт

Жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн талаарх мэдээлэл

№	Даатгалын тохиолдлын утга	Цагдаагийн байгууллагаас даатгалын тохиолдолд үзлэг хийсэн эсэх	Нөхөн төлбөр авсан этгээдийн овог, нэр	Даатгалын компани	Даатгалын гэрээний дугаар	Нөхөн төлбөр олгосон үндэслэл					ТХ-ийн улсын бүртгэлийн дугаар	ТХ-ийн гэрчилгээний дугаар
						Даатгалгүй этгээд тохиолдол гаргасан	Даатгалын гэрээний хугацаа дууссан этгээд хохирол гаргасан	Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус	Даатгагч дампуурсан	Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл		
1												
2												
3												
4												
	Нийт											

Мэдээ гаргасан:
Холбооны ажилтан

/...../

Тамга

Холбооны Ажлын албаны дарга

/...../